



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/357

Номгон


Үржлийн малд үзлэг, ангилалт хийх,
баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а” заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.6.4 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах ажлыг 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны хооронд үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, малын удам зүйн үнэлгээний программын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Баттөр)-т үүрэг болгосугай.

2. Бог малын хээлтүүлэгчийг малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлж, мэргэжлийн байгууллагын мэдэлд шилжүүлэн ашиглуулах хуулийн заалтыг хэрэгжүүлж, хээлтэгч хээлтүүлэгчийн зохистой харьцааг баримтлан тухайн бүс нутагт ашиглахаар зөвшөөрөгдсөн хээлтүүлэгчээр дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, өсвөр хээлтүүлэгч шилж сонгох, холбогдох тайлан, мэдээг Хүнс, хөдөө аж ахуйн газарт хагас, бүтэн жилээр тайлагнахыг сумдын Засаг дарга, мэргэжлийн нэгжийн дарга, захирал нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Г.Хишигбаатар/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

521010625